МБҮА





ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОВХИМОЛ

2024.10-р сар

+(976) 7011 1515 www.mnca.mn info@mnca.mn


JIGUUR GRAND GROUP
Макс
МАКС ӨРГӨӨ
TSAST
for clean life
Royal New Castle
ultrasonic
NCD
NBTK
ZAG GROUP
BASALTWOOL
ERELT IMPEX
MCS
property LLC
БҮТИ
UGUUJ KHISHIG CO.,LTD
T&G
GREEN
RESOURCE
SD
ENGINEERING & CONSTRUCTION
ERIN
INTERNATIONAL
ERCHIM ENGINEERING LLC
ChMM
construction
SERUUN
SINCE 1991
БАТС-ӨРГӨӨ ХХК
MONCON
MONGOLIAN CONSTRUCTION GROUP
barilga.mn
БУЯНПЭЛ ХХК
БАРМОН
RENDERBAU
BRIDGE
CONSTRUCTION
TCSO
DYNAMIC TOWER
VIP RESIDENCE
UNISTEEL
CONSTRUCTION
SKETCH LLC
EFES CONSTRUCTION
ТУМ АРВИЖИХ
БОДЬ ИНТЕРНЭШНЛ
GR PRECAST CO.,LTD
InvesCore
PROPERTY LLC
BDMT
BUSINESS DEVELOPMENT & MANAGEMENT TEAM
СҮНДЭР ОРГОО ТРЕЙД ХХК
ОФФИС ПАРТНЕР
HIMON
DOBU
ТАВАН БОГД ПРОПЕРТИ ХХК
Хамтын хуч - Амжилтын түлхүүр
АЛТАН ЖОЛОО КОНСТРАКШН
BAGANAT URGUU COMPANY
HYUNDAI
ХЬЁНДЭ ЭЛЕВАТОР МОНГОЛ ХХК
ТОПОЛОГИ ХХК
ЭРЧИМ ХҮЧ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ДЭД БҮТЭЦ
NEW TELECOM
RENDER
TRADE
Ecological
Civil
Construction
ProHeat
Heating & Construction
ХУРД ГРУПП
ТЭНХЛЭГ ЗУУЧ
УЛ ХӨДӨЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
GLOBAL
TELECOM
БАЗУРА
ДИЗАЙН
N.A.P GROUP
MINES UP
UB GROUP
EUROZIGI
ENGINEERING Co.,Ltd
АРГАЛАНТ АРВИС ГРУПП
SOYOLON
ENGINEERING
НОМИН ХИШЭЭЛ
ХАЙРХАН ГРУПП
MCS
estates
ЦАГААН УРИЛ ХИЙЦ
"БОДЬ ЦОГТ" ХХК
"AGGS" LLC
BUTANGUUD
CONSTRUCTION LLC
PD
Solutions LLC
МОНГОЛ АЛТАЙН ЦАГ
HOME
MORTGAGE
CORPORATION
ULAANBAATAR
PROPERTIES
BULDOORS MON
PERFECT DOOR SOLUTIONS
НУТГИЙН БУЯН ГРУПП ХХК
МИШЭЭЛ ГРУПП
Смарт Грийн Девелопмент
GLOBAL
ELECTRONICS
GOLDEN LIGHT
GROUP
INTERNATIONAL
АЛХ ХАДААС ХХК
ХАНГАЙН ИЛЧ ДУЛААН ХХК
БАЯНСУНДЭРЭЛ
ЭВЭР ТУУРАЙ
BOLD
daco
IG CON
ENGINEERING CONSULTANTS
ИНК
ИНСТАЛЛ НАРАН КОНСТРАКШН
"АТИМОС ТРЕЙД" ХХК
eGO
ENGINEERING & CONSTRUCTION
MONGOL 333
CORPORATION
РАДИУС ХХК
ЦАГААН ХӨШӨӨ ТРЕЙД
SILVER TOWER
Oortsog-Uul
ГУРВАН БУХАТ ГРУПП
ИМ
ИХ МОДУЛ ХХК
A1
ARCHITECTS
MANDALT
CONSTRUCTION Co.,Ltd
АССЭ ХХК
CHOKWANG
CHOKWANG PAINT
ENDLESS
energy
ZINDAA
CONSTRUCTION
O&OCH LLC
NATIONAL
CONSTRUCTION
CONSULTING
SERVICES
HAPPY BUILDING LLC
RICHWELL
ENGINEERING LLC
RE/MAX
RE/MAX STAR
DKH
ДЭЛГЭРЭХ ТАВАН ЧАНДМАНЬ ХХК
VISION DEVELOPMENT LLC
ГАНЬТ
CONSTRUCTION AND TRADING
ОРГИЛ ЖИЙМ
ХАРХОРИН - ОРГОО ХХК
LegalLink
NOMAD'S
NR
ROAD
MPI
consultants
PETROLEUM CONSULTING & ENGINEERING
SATRADE
NAB GROUP
NATIONAL ADVANCED BUSINESS
TML
MIRC
CONCRETE
PARCO
FACADE LLC

ОРШИЛ

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь өөрийн байгууллагын Эрхэм зорилго, зорилтын хүрээнд зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчимд нийцсэн барилгын салбарын тогтвортой байдлыг хангах, засаглалын зөв тогтолцоог бий болгох, салбарын эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан урт, богино хугацааны бодлогын болон стратегийн бичиг баримтыг боловсруулахад нөлөөлөх, суурь судалгааг хийх, салбарын чадавхыг сайжруулах чиглэлд салбарын яам, холбоод, иргэний нийгэм, гадаадын төсөл, хөтөлбөр болон олон улсын байгууллагуудтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн олон талаар хамтран ажилладаг билээ.

Дээрх эрхэм зорилго, зорилтын хүрээнд МБҮА ТББ-ын Ажлын алба нь 2024 оны 10 дугаар сард хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ, үйл ажиллагааныхаа тайланг байгууллагын “Стратеги төлөвлөгөө 2020-2024”-ийн зорилтын дагуу товхимол хэлбэрээр бэлтгэн хүргэж байна.

АГУУЛГА

01 **ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.1**

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

02 **ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.2**

ГИШҮҮДЭД ЗОРИУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

03 **ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.3**

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

04 **ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.4**

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

05 **ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.5**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

06 **ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.8**

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

07 **ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.6**

ОЛОН УЛСЫН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

2024.10-р сар

MNCA
MONGOLIAN NATIONAL CONSTRUCTION ASSOCIATION
SINCE 2009
15 anniversary

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.1:

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖИЛ



+(976) 7011-1515

www.mnca.mn

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ НЬ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААРАА ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛААР М.БАТСҮХИЙГ ТОМИЛЛОО



МБҮА ТББ-ын удирдах зөвлөлийн ээлжит III хурал нь 2024.10.25-ны өдөр боллоо. Хурлаар 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөний төсөлд сайжруулалт хийж, хүлцэж болох зардлыг бууруулж, он дуустал хугацаанд хийх ажлыг тодотгосон төслийг хэлэлцэн хөндлөнгийн аудитын байгууллагаар МБҮА ТББ-ын үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийлгэх зардлыг хэлэлцэж, МБҮА ТББ-ын 15 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн баталлаа. Мөн хурлаар барилгын салбарын мэргэжлийн нэгдсэн холбоог байгуулах бэлтгэл ажлын явцын танилцуулга, энэ ажлын цар хүрээг өргөтгөх бодлого, зорилтыг хэлэлцэн, барилгын салбар, гишүүн байгууллагуудад “Дулаан шийдэл-2” төслийн үзүүлэх үр нөлөө, төслийн 10 хувийн хамтарсан санхүүжилтийг бүрдүүлэх, санхүүжүүлэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.


Тус хурлаар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх нь Нийслэлийн 22-р дунд сургууль, 47-р дунд сургууль, 1999 онд МУИС-ийг Эдийн засагч, мэдээлэл зүйч, 2011 онд Удирдлагын академийг Бизнесийн удирдлагын мэргэжлээр тус тус төгссөн.

2007 онд Монголын барилгын нэгдсэн портал Barilga.mn сайт, 2010 онд Барилга.МН сэтгүүлийг үүсгэн байгуулсан. 2012-2014 онд БХБ-ын сайдын зөвлөлийн гишүүнээр, 2017 онд БХБ-ын сайдын орон тооны бус зөвлөхөөр, БХБЯамны дэргэдэх Ногоон барилгын зөвлөлийн гишүүнээр тус тус ажиллаж байсан ба Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг зохицуулалттай болгох судалгаа болон хуулийн төсөл боловсруулах, барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэгт ажилласан.

Тэрээр Барилгын норм дүрэм, стандартын үзлэг болон Барилгын материалын тохирлын гэрчилгээ олгох үйл ажиллагааг зохион байгуулахад оролцож, Барилгын материал үйлдвэрлэл, Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн ажлын хэсгийн даргаар ажиллаж БХБЯамны захиалгаар хийгдсэн тусгай зөвшөөрлийн цахим программыг шинэчлэн сайжруулах ажилд оролцож ажилласан.

Өнгөрсөн хугацаанд барилгын салбартаа “Barilga expo”, “Барилга орон сууц” зэрэг үзэсгэлэн яармагууд, Барилгын ханган нийлүүлэгчдийн чуулган, Барилгын хөрөнгө оруулагчдын уулзалт, Барилгын маркетинг, Барилгын чанар аюулгүй байдал зэрэг олон арга хэмжээнүүдийг зохион байгуулсан бөгөөд салбарын мэдээ мэдээллийг олон нийтэд түгээж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дуу хоолойгоо хүргэж ирсэн.

АЖИЛ ОЛГОГЧДОД ДАРАМТ БОЛЖ БУЙ НД-ИЙН ХУУЛИЙН ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ ХҮСЭЛТИЙГ МБҮА ТББ НЬ ГБХНХ-нд ТАВИЛАА



МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ
Монгол Улс, Улаанбаатар 15141, Чингэлтэй дүүрэг,
5 дугаар хороо, Самбуугийн гудамж 24,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот
Утас: + (976) 7011 1515
Утас: + (976) 7018 5055, + (976) 7018 5055
И-мэйл: info@mnca.mn, Веб: www.mnca.mn

2024.10.31 №24/80/АА

Танай ____ны №____-т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Хуулийн заалт хүчингүй болгох тухай

Эрхэм хүндэт Таны энэ өдрийн амар амгаланг айлтгаж, ажил үйлсад нь амжилт хүсэн мэндчилье.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь барилгын салбарт сайн засаглалыг бий болгоход төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, уялдаа сайжруулж, хууль эрх зүйн орчинд шинэчлэл хийхэд нөлөөлж, гишүүдийн чадавхыг сайжруулах, барилгын зах зээлийн тогтвортой өсөлтийг хангахад хувь нэмрээ оруулах эрхэм зорилготойгоор 2009 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд өдгөө барилгын салбарт үйл ажиллагаагаа явуулж буй томоохон хөрөнгө оруулагч, хөрөнгөлөгч, барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэгч, зуураг төсөл боловсруулах болон хангах нийлүүлэгч байгууллагуудыг эгнээндээ нэгтгэн мэнлэйлэн ажиллаж буй ашгийн бус, салбарын мэргэжлийн төрийн бус байгууллага юм.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19.1.2 дугаар заалтад "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан Ажил гүйцэтгэх, Хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс"-ийг даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд оруулж тооцон нийгмийн даатгалын шимтгэл авахаар заасан нь хууль бус агуулгатай байна.

Дэлхийн аль ч улс оронд Иргэний хуулиар зохицуулах гэрээний дагуу олж байгаа орлогыг Хөдөлмөрийн хуультай адилтган, шимтэл авдаг улс байхгүй байна.

Иймд "Нийгмийн даатгалын ерөнхий хууль"-ийн 19.1.2 заалтыг хүчингүй болгох асуудлыг зохих журмын дагуу Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэхийг хүсэж байна.

Хамтын ажиллагаанд талархав.

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТСҮХ

Нийгмийн даатгалын ерөнхий хууль"-ийн 19.1.2-р заалтад "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс"-ийг даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд оруулж тооцон нийгмийн даатгалын шимтгэл авахаар заасан нь хууль бус агуулгатай болгох асуудлыг зохих журмын дагуу Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэхийг хүсэж байгаагаа гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд Л.Энх-Амгаланд албан хүсэлт илгээлээ.

МНХ-НЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХЭРЭГЖИЖ ЭХЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААН 4 УДАА БОЛЛОО





Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль нь 2025.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчдийн зөвлөлийн хурлаас 2024.09.12-ны өдөр "Ажлын хэсэг"-ийг МБҮА ТББ-ын Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатараар ахлуулж Дэд ерөнхийлөгч, НБИК ХХК-ийн Гүйцэтгэх захирал Баяраа, Дэд ерөнхийлөгч,Номин констракшн девелопмент групп -ийн гүйцэтгэх захирал Б.Хүрэлхүү, УЗГ, Эс Ди Инженеринг Энд Констракшн ХХК-ийн захирал Б.Баасансүрэн, Н ЭЙ БИ ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Б.Амарсанаа нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Энэ удаагийн ээлжит №3 хуралдаанаар хууль боловсруулсан багийн хуультай уулзалт хийх, УБЕГ, НДЕГ-аас тодруулга авах албан бичиг явуулах бас яам руу бичиг явуулах, Хууль зүйн зөвлөх үйлчилгээ авах асуудлыг УЗ-д танилцуулж шийдвэр гаргуулах, МНХ-ны дүрмийн төсөл боловсруулах ажлыг эхлүүлэх тал дээр санал бодлоо солилцлоо. Дөрөв дахь удаагийн хурлаар барилгын салбарын төрийн бус байгууллагуудын талаарх нэгдсэн судалгааг гарган ямар шатанд ажиллах талаарх ойлголцолд хүрлээ.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.2

ГИШҮҮДЭД

ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилтын хүрээнд холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласны үр дүнд 2024.10-р сард барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэл үйл ажиллагаа эрхэлж буй гишүүдийг АЖИГЛАГЧ ГИШҮҮН-ээр 34 гишүүнд мэдээ мэдээллийг өгч ажиллалаа.

БАРИЛГЫН ГОЛОГДЛООС БОЛЖ ХУГАЦАА ХОЙШЛОЛТ БОЛОН МАРГААНЫ АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭЖ БАЙГАА ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ МБҮА ТББ-ЫН ГИШҮҮД АВЧ МАЛАЙЗЫН МАСТЕР БАРИЛГАЧДЫН ХОЛБООНЫ СЕРТИФИКАТТАЙ БОЛЛОО


MBAM
MASTER BUILDERS ASSOCIATION MALAYSIA
PERSATUAN KONTRAKTOR BINAAN MALAYSIA
E-Certificate of Attendance
is presented to
BYAMBAA SARANCHIMEG
MONGOLIAN NATIONAL CONSTRUCTION ASSOCIATION
For attending the
MBAM Contract Admin Programme – Session 3
The Trouble with Building Defects
New Trouble beyond Delay and Quantum Disputes
'Losing more than your Pants'
Held on 11 September 2024, Wednesday (5pm – 7 pm)
Organised by MBAM Contracts & Practices Committee
This e-certificate is issued by MBAM and authorised by
Ir Anthony Teoh
Chairman of Contracts & Practices Committee


MBAM
MASTER BUILDERS ASSOCIATION MALAYSIA
PERSATUAN KONTRAKTOR BINAAN MALAYSIA
E-Certificate of Attendance
is presented to
BORIS BAASANSUREN
MONGOLIAN NATIONAL CONSTRUCTION ASSOCIATION
For attending the
MBAM Contract Admin Programme – Session 3
The Trouble with Building Defects
New Trouble beyond Delay and Quantum Disputes
'Losing more than your Pants'
Held on 11 September 2024, Wednesday (5pm – 7 pm)
Organised by MBAM Contracts & Practices Committee
This e-certificate is issued by MBAM and authorised by
Ir Anthony Teoh
Chairman of Contracts & Practices Committee


MBAM
MASTER BUILDERS ASSOCIATION MALAYSIA
PERSATUAN KONTRAKTOR BINAAN MALAYSIA
E-Certificate of Attendance
is presented to
BATCHIMEG ONON
MONGOLIAN NATIONAL CONSTRUCTION ASSOCIATION
For attending the
MBAM Contract Admin Programme – Session 3
The Trouble with Building Defects
New Trouble beyond Delay and Quantum Disputes
'Losing more than your Pants'
Held on 11 September 2024, Wednesday (5pm – 7 pm)
Organised by MBAM Contracts & Practices Committee
This e-certificate is issued by MBAM and authorised by
Ir Anthony Teoh
Chairman of Contracts & Practices Committee

Малайзын Мастер Барилгачдын Холбоо (MBAM)-ноос 2024.09.11-ны өдөр зохион байгуулсан “Барилгын гологдлоос үүдсэн асуудал, хугацаа хойшлолт ба тоо хэмжээний маргааны асуудал” сэдэвт сургалтад МБҮА ТББ-ын УЗГ Эс Ди инженеринг энд констракшн ХХК-ийн захирал Б.Баасансүрэн, МБҮА ТББ-ын Ажлын албаны менежер Б.Саранчимэг, МБҮА ТББ-ын гишүүн Эм Си Эс проперти ХХК-ийн барилга хариуцсан Дэд захирал Г.Эрдэнэбаатар, гэрээ, төсөв хариуцсан Дэд захирал О.Батчимэг, төслийн хяналт хариуцсан Дэд захирал Г.Молор-Эрдэнэ, Инженерингийн албаны дарга С.Чинзориг нар оролцлоо. Энэхүү сургалтаар барилгын гологдол гэж юу вэ, яагаад гологдол гардаг, үүнээс үүдэж ямар үр дагавар гардаг талаарх мэдээллийг Малайз Улсын жишээгээр тайлбарлаж, дүн шинжилгээ хийж улмаар оролцогчдод сертификат гардууллаа. Мөн МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагуудын төлөөлөгчдийг сургалтад оролцох боломж олгож, сертификат ирүүлсэнд талархал илэрхийлж и-мэйлийг Х.Фарах Алиагаар дамжуулан илгээв. Дашрамд хэлэхэд энэхүү цуврал сургалтууд нь МБҮА ТББ-ын бүх гишүүдэд нээлттэй, үнэ төлбөргүй бөгөөд өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлэхэд чухал хэрэгтэй гэдгийг онцлох байна.





ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.3

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 80 ГАРУЙ БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧ “ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХАА ИЛЭРХИЙЛЛЭЭ



МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл II” төслийн баг нь 2024.09.13-10.06-ны хооронд Дархан-Уул аймгийн бичил, жижиг бизнес эрхлэгчдийн дунд нээлттэй элсэлтээ зарлаж, бүртгэв. Тус элсэлтийг МБҮА ТББ, Дулаан шийдэл төсөл, Жэрэс ОУТББ, Монголын Эмэгтэйчүүдийн Сан, Дулаалгын хялбар шийдэл аян, Монголын Ногоон Санхүүгийн Корпораци, Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ, Европын холбооны санхүүжилттэй Найрамдал төсөл, Дархан-Уул аймгийн ХХААГ зэрэг байгууллагын фэйсбүүк хуудас болон Дархан хотын барилгын салбарын нэгдсэн мэдээлэл фэйсбүүк групп, Дархан-Уул аймгийн барилгачдын холбоогоор дамжуулан олон нийтэд зарлалаа. Үүний үр дүнд Дархан-Уул аймгийн 80 гаруй барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчид “Дулаан шийдэл II” төсөлтэй хамтран ажиллахаа илэрхийлсэн юм.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД БАЙГУУЛЛАГЫНХАА БОЛОН ТӨСЛИЙНХӨӨ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАНИЛЦУУЛАВ



Төсөлтэй хамтран ажиллахаа илэрхийлсэн Дархан-Уул аймгийн барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчдэд 15 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж буй байгууллагаа болон төслөө танилцуулах уулзалт 2024.10.15-нд тус аймгийн ХААИС-д боллоо. Уулзалтад Жэрэс ОУТББ, Барилгын Эрчим Хүч Хэмнэлтийн Төв, Монголын Эмэгтэйчүүдийн Сангийн холбогдох төлөөлөл оролцож, тус тус төслийн хүрээнд хэрэгжүүлж буй чиг үүргээ танилцуулав. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойших эхний хоёр жилийн хугацаанд барилгын салбарын 7650 бичил, жижиг бизнес эрхлэгчдэд эрчим хүчний хэмнэлт, дулаалгын зах зээлийн талаар мэдээлэл өгч, 119 барилгын ажилчдыг



дулаалгын технологид сурган, шинээр 35 дулаалгын зөвлөх бэлтгэн чадавхжуулаад байна. Тэгвэл МБҮА ТББ-ын төслийн багаас Дархан-Уул аймгийн бичил, жижиг бизнес эрхлэгчдэд зориулан зурагт харуулсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа юм. 2022-2023 онд төслийн хүрээнд “Хялбар шийдэл” аяныг Улаанбаатар хотын 4 дүүргийн 22 хороонд хэрэгжүүлсний үр дүнд 19200 айл өрхөд эрчим хүчний хэмнэлтийн талаар мэдээлээл хүргэн, 1694 айл өрхөд дулаалгын хялбар шийдлийг хэрэгжүүлж, 200 өрхөд

дулаалгын багц олгон, 44 сургагч багшийг бэлтгэж, 249 айлын дээврийг 5 см-аар үнэгүй дулаалаад байна. Мөн адрын хөндийн болон мансардтай дээвэр, дотор болон гадна хана, суурийн дулаалгын шийдлүүдийг боловсруулан, дулааны насос, нарны зайн хураагуурын систем зэрэг сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжүүдийг санал болгон, эрчим хүчний хэмнэлттэй загвар сууцны зураг төслүүдийг гаргаад байгаа юм. Түүнчлэн 840 мянга гаруй иргэнд ногоон зээлийн талаар мэдээлэл өгч, 4 арилжааны банк, 3 ББСБ-тай хамтран ажиллан, 50 орчим өрхөд ногоон зээл олгосон. Ийнхүү энэ оны 9, 10 дугаар сараас эхлэн Дархан-Уул аймагт хүрээгээ тэлж байгаа нь төслийн хувьд чухал зорилтуудынхоо нэгийг хэрэгжүүлж буй явдал юм.

ДАРХАН-УУЛ АЙМАГТ ДАВХАРДСАН ТООГООР 114 БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙГ ЧАДАВХЖУУЛЖ, 22 ДУЛААЛГЫН АЖИЛТАН БЭЛТГЭЛЭЭ

“Дулаалгын технологи” сургалт:




- **Огноо:** 2024.10.17-10.18
- **Байршил:** Дарханы Политехник коллеж, хичээлийн 3-р байр
- **Хамрагдсан хүний тоо:** 29
- **Гол агуулга:** Дулаалгын төрлүүд, технологийн дагуу дулаалах арга аргачлал
- **Зохион байгуулагч:** ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв
- **Багш:** Ахлах инженер Ж.Ганхуяг
- **Хамтрагч:** МБҮА ТББ

“Барилгын салбар дахь жендэрийн асуудал” сургалт:




- **Огноо:** 2024.10.16
- **Байршил:** Дарханы ХААИС
- **Хамрагдсан хүний тоо:** 29
- **Гол агуулга:** Барилгын салбарт төрөөс баримталж буй жендэрийн бодлого, барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй жендэрийн асуудлыг шийдвэрлэх арга зам
- **Зохион байгуулагч:** МБҮА ТББ
- **Хамтрагч:** Монголын эмэгтэйчүүдийн сан, Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, МУИС
- **Багш:** Хүрээлэнгийн захирал Ц.Одгэрэл, доктор, профессор Т.Бүрэнжаргал

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЧАДАВХЖУУЛАХ БАГЦ ХӨТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

Багц сургалт №1: “Дулаалгын ажилтан”			
№	Сургалтын нэр	Сургалтын үргэлжлэх хугацаа	Огноо
1	Барилгын салбар дахь жендэрийн асуудал	1 өдөр/8 цаг	2024.10.16
2	Барилгын хог хаягдлын менежмент		
3	Дулаалгын технологи	2 өдөр/16 цаг	2024.10.17-10.18
4	Нийт ажилтнуудад зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	1 өдөр/8 цаг	2024.10.19
Нийт үргэлжлэх хугацаа		4 өдөр/32 цаг	

“Нийт ажилтнуудад зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сургалт:




- **Огноо:** 2024.10.19
- **Байршил:** Дарханы ХААИС
- **Хамрагдсан хүний тоо:** 32
- **Гол агуулга:** Аюулыг тодорхойлох, хариу арга хэмжээ авах, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл ашиглах, анхны тусламж үзүүлэх, галын хор хэрэглэх зааварчилгаа гэх мэт
- **Зохион байгуулагч:** МБҮА ТББ
- **Хамтрагч:** Номин конструкшн девелопмент ХХК-ийн дэргэдэх Соёл түгээгч дуулгатан ТББ
- **Багш:** Н.Очирбат, н.Энхжаргал, н.Отгонбаатар, н.Жаргалсайхан

Эхний шатны “Дулаалгын ажилтан” багц хөтөлбөрт багтсан дээрх дөрвөн төрлийн сургалтыг 2024.10.16-10.19-ний хооронд зохион байгуулж, давхардсан тоогоор тус аймгийн 114 бичил, жижиг бизнес эрхлэгчийг чадавхжуулж, 22 дулаалгын ажилтан бэлтгээд байна.

НИЙТ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ХАБЭА-Н СУРГАЛТАД ХАМРАГДАЖ, ШАЛГАЛТДАА ТЭНЦСЭН ХҮМҮҮСИЙНХЭЭ СЕРТИФИКАТЫГ ГАРДУУЛАВ





ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “НАЙРАМДАЛ” ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН “НОГООН БАРИЛГА” СЭДЭВТ СУРГАЛТЫГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ БОЛОМЖИЙН ТАЛААР ХЭЛЭЛЦЛЭЭ





2024.10.18-нд тус төслийн багтай хамтран “Ногоон барилга” сэдэвт сургалтыг зохион байгуулах боломжийн талаар уулзалт хийлээ. Уулзалтаар “Найрамдал төсөл”-ийн хувьд хэрэгжих хугацаандаа 10 төрлийн модуль сургалтыг олон салбарт зохион байгуулахыг зорьж байгаа ба одоогоор 8 төрлийн модуль сургалтаа зохион байгуулсан. Үлдсэн 2 модуль сургалтын нэг нь "Ногоон барилга" чиглэлээр Дархан-Уул аймгийн барилгын салбарынхны дунд зохион байгуулахаар зорьж байгаа тэдийгүй Барилгын Эрчим Хүч Хэмнэлтийн Төв (БЭХХТ)-ийн захирал Б.Мөнхбаяр сургалт оруулах хүсэлтэй байна. Мөн сургалтын үргэлжлэх хугацаа 2 өдрийн буюу эхний өдрийн сургалт танхимынх, 2 дахь өдрийн сургалт бодит орчинд байх шаардлагыг тавьдаг. Улмаар сургалтад оролцогчдоос “Найрамдал” төслийнхөн сэтгэл ханамжийн судалгаа авч, хүрсэн үр дүнг тодорхойлж, санхүүжүүлэгчдэдээ тайлагнадаг тухайгаа дурдлаа. Харин “Дулаан шийдэл II” төсөл нь барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зорилгоор 2018 оноос хойш 10 хүртэлх төрлийн сургалтыг 11 дэх удаагаа зохион байгуулсан. Тус төслөөр чадавхажсан, идэвхтэй хамтран ажилладаг бичил, жижиг бизнес эрхлэгчдээс судалгаа авсны үр дүнд, өнгөрсөн жилээс БЭХХТ-тэй хамтран "Эрчим хүчний хэмнэлттэй халаалтын систем, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд" сэдэвт гүнзгийрүүлэх шинэ сургалтыг зохион байгуулж эхэлсэн. Энэ сургалт нь оролцогчдоос өндөр үнэлгээ авсан. Мөн БЭХХТ нь GIZ-тай хамтран сургалтууд зохион байгуулж байгаа бөгөөд 2 талууд хамтран ажиллах боломжтой гэдгээ илэрхийллээ. Мөн тус сургалтыг “Найрамдал” төсөлтэй хамтран хэрэгжүүлэхээр бол Жэрэс ОУТББ-аас нэгдсэн удирдлагаар хангах, МБҮА ТББ-ын Төслийн баг нь барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, сургалтын ерөнхий зохион байгуулагчаар ажиллах, БЭХХТ-өөс сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтаа орох боломжтой гэсэн саналаа төслийн менежер Г.Мөнхтуяа илэрхийллээ.

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН НЭЭЛТ ДАРХАН-УУЛ АЙМАГТ БОЛЛОО





Европын Холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслийн Хөндлөнгийн Зөвлөх Хорооны хурал 2024.10.23-нд Дархан-Уул аймагт зохион байгуулагдлаа.

Энэ удаагийн хурлаар төслийг Дархан-Уул аймагт хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлууд болон Дарханд хөндлөнгийн зөвлөх хороо байгуулах талаар хэлэлцэв. Уг хороо нь төслийн нөлөөллийн ажилд зөвлөх, хэрэгжилтийн үйл явцыг хянах, дэмжих чиг үүрэгтэй байдаг.

Хуралд Дархан-Уул аймгийн ЗДТГ болон Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, Дархан-Уул аймгийн Барилгачдын холбоо, аймгийн Байгаль орчны газар, төслийн оролцогч талууд болон ижил төстэй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагууд, олон улсын, төрийн байгууллагын төлөөлөл 40 орчим хүн оролцлоо. Тэр дундаа МБҮА ТББ-ын гүйцэтгэх захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Ж.Бат-Эрдэнэ, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах менежер Б.Төвшинболор, төслийн менежер Г.Мөнхтуяа нар оролцож, байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчлан таниулсан юм.

МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл II” төслийн баг нь 2024.09.13-10.06-ны хооронд Дархан-Уул аймгийн бичил, жижиг бизнес эрхлэгчдийн дунд нээлттэй элсэлтээ зарлаж, бүртгэв. Улмаар 2024.10.16-10.19-ны хооронд “Барилгын салбар дахь жендэрийн асуудал”, “Барилгын хог хаягдлын менежмент”, “Дулаалгын технологи”, “Нийт ажилтнуудад зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт” гэсэн 4 төрлийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 114 бичил, жижиг бизнес эрхлэгчийг чадавхжуулж, 20 гаруй дулаалгын ажилтанг бэлтгээд байна. Үргэлжлүүлэн, 2024.10.29-11.02-ны хооронд дараагийн ээлжийн багц сургалтаа зохион байгуулж, идэвхтэй хамрагдсан барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчидтэй Хамтран ажиллах Санамж бичиг байгуулан, эрчим хүчний хэмнэлт, дулаалгын зах зээлтэй холбохоор төлөвлөн ажиллаж байгаагаа МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл II” төслийн менежер Г.Мөнхтуяа танилцуулсан юм.

Мөн тэрбээр, Дархан-Уул аймагт төслийг амжилттай хэрэгжүүлэхэд, орон нутгийн байгууллагуудын санаачилга, оролцоо, дэмжлэг, барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчдийн идэвх, хичээл зүтгэл, айл өрхүүдийн дулаалгын эрэлт хэрэгцээ, аж ахуйн нэгжүүдийн ач холбогдол өгөх байдал гэх мэт чухал нөлөөтэйг хэллээ.


Мөн Хялбар шийдэл аяны хүрээнд тус аймгийн Дархан сумын 1, 2, 3, 5, 6-р багт нийт 10-15 сургалт зохион байгуулах, 70 айлын дээврийг 5 см-аар дулаалах, 350 айл өрхөд хялбар шийдэл хэрэгжүүлэх, 30000 иргэнд мэдээлэл хүргэх зорилго тавин ажиллаж байгаа тухайгаа Монголын эмэгтэйчүүдийн сангийн Дулаан шийдэл II төслийн менежер Г.Гантулга ярилаа.

Арга хэмжээний үеэр төслийн хүрээнд Дархан-Уул аймаг дахь Төслийн хөндлөнгийн зөвлөх хороог байгуулах, тус хороо нь төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг чиг үүрэг хэрэгжүүлэхээр болсон юм.

УБ БОЛОН ДАРХАН-УУЛ АЙМГИЙН БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ХАМТРАН АЖИЛЛАХ ЭХЛЭЛИЙГ ТАВИЛАА



Д/д	Дулаалсан эзэлхийн нэр	Одоо хийж буй ажил	Тэл ажиллагаанд чиглэл/Хамтран ажиллах санал	Холбоо барих утасны дугаар
1.	Э.Хатантөмөр	Хуньдэл байшин барьж, дулаалж байна.	Уусарнаа орон сууцны дулаалсан ажил гүйцэтгэх ажлуд хамтран ажиллах хүсэлтэй байна.	99135724
2.	Ц.Цогт-Эрдэнэ	Нотоон зоогийн санхүүжилтээр агаар сэлгэлтийн хана, дээврийн дулаалсан ажил хийж гүйцэтгэж байна.	Орчин үеийн модон барилгын барилтын технологи нэвтрүүлэх, ашиглах орон сууц дулаалах	99089391
3.	Ч.Сүмъяабат	Хэд хэдэн дулаалсан ажил хийж байна. Хэлбэр шийдэл өлиш хүрээд Баянгол дүүргийн 3 цэцэрлэгийн цонх, хаалганы рекламийг солилоо.	Дулаалсан ажил хамтрад хийх боломжтой. Цонхр, бэхэлсэн систем мутлашуулж, суурилуулж байна.	89225823
4.	М.Бямбасүрэн	Дархан-Уул аймгаас холбогдож байна. Одоогоор гэр бүлийн хүчийсэн хийж буй барилтын ажилд туслаж байна.	Плананы ажлаар хамтарч ажилтаж болохоотой	99912537
5.	Г.Золзаяа	Дархан-Уул аймгаас холбогдож байна. Барилтын дотор засал хийдэг.	Барилтын дотор засал, чимэглэлийн ажлаар хамтарч ажилтаж болохоотой.	88879219
6.	М.Майкидэр	Дархан-Уул аймгаас холбогдож байна. Үндсэн мергэжил мөнөө механик инженер. Одоогоор ашиглаа компанийн ажилд туслаж байна.	Барилга, сантехник, ажилчдын сэнсдэнсэн барилга, цахилгааны угсралт гэх мэт олон чиглэлээр хамтарч ажилтаж болохоотой	80106779
7.	Ш.Баярсайхан	Одоогоор өөрийн байшиндаа засвар, дулаалга хийж байна.	Аймаг орон сууцны угсралт болон дотор засал чимэглэл, байшингийн дулаалга	99200400
8.	Т.Бизэр	Дээврийн дулаалга хийж гүйцэтгэж байна.	Эрчим хүчний хэмнэлттэй барилга барих чиглэлээр ажилтаж сонирхоотой байна.	98511482



“Та барилгын ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг вэ, одоогоор ямар барилгын ажил хийж байна?” гэсэн сэдвээр төслийн дулаалгын зөвлөхүүд, төслөөр чадавхжиж буй бичил, жижиг бизнес эрхлэгчдийн дунд сар тутам зохион байгуулдаг онлайн уулзалтаа хийлээ. 2024.10.21-нд болсон энэхүү уулзалтаар УБ болон Дархан-Уул аймгийн барилгын салбарын бичил, жижиг бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг хооронд нь уялдуулах, хамтран ажиллах эхлэлийг тавьсан ба уулзалтаар БЭХХТ-ийн инженерүүд төслийн техникийн үнэлгээ, дулаалгын ажил хийж гүйцэтгэхдээ анхаарах зарим асуудлын талаар дулаалгын зөвлөхүүдэд зөвлөмж өглөө.

МБҮА ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ТӨСЛИЙН БАРИЛГЫН САЛБАР БОЛОН ГИШҮҮН КОМПАНИУДАД ҮЗҮҮЛЖ БУЙ ҮР НӨЛӨӨГ ТАНИЛЦУУЛЛАА





2024.10.25-нд болсон МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн ээлжит III их хурлаар “Дулаан шийдэл II” төслийн 2022.05.01-2024.10.25-ныг хүртэл барилгын салбар болон гишүүн компаниудад үзүүлж буй зарим онцлох үр нөлөөг танилцуулсан юм. МБҮА ТББ нь гишүүддээ төдийгүй нийгэмдээ үйлчилдэг төрийн бус байгууллага гэж дотоод, гадаадын байгууллагуудад танилцуулагддаг бөгөөд “Дулаан шийдэл II” төсөл нь байгууллагынхаа нийгэмдээ үйлчилж буй тод илрэл, бодит алхам болоод зогсохгүй нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран хэрэгжүүлж буй төсөл юм. МБҮА ТББ нь Европын холбооны Свич Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслийг хамтран хэрэгжүүлснээр барилгын салбартаа, гишүүн компаниуддаа нийтдээ 597,536,553 төгрөгийн мөнгөн өгөөж, бодит хөрөнгө оруулалтыг хийгээд байна. Мөн МБҮА ТББ нь Өмнөговь аймагт болон Дархан-Уул аймагт үйл ажиллагааныхаа хүрээг тэлэх боломж бүрдээд байна.

ДАРХАН-УУЛ АЙМАГТ “ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХ”-ҮҮДИЙГ БЭЛДЭЖ БАЙНА

"Дулаан шийдэл 2" төслийн "Дулаалгын зөвлөх" багц сургалтын хуваарь, төлөвлөгөө

Д/д	Төлөвлөж буй ажил	Огноо	Үргэлжлэх хугацаа	Байршил	Зээмшүүлэх мэдлэг, мэдээлэл, давуу тал	Тайлбар
1	Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ сургалт эхний өдөр	2024.10.29	10:30-17:30	Дарханы ХААИС, урлаг заал	Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, хэмжих	Цайны завсарлагатай
2	Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ сургалт хоёр дахь өдөр/+Зах зээл, маркетинг, борлуулалт, дулаалгын платформ	2024.10.30	09:30-17:00		Дулаалгын үнэлгээ, тооцоолол гаргах, маркетинг, борлуулалтаа хийх, төслийн захиалгат ажлуудыг гүйцэтгэх тухай	Цайны завсарлага, өдрийн хоолтой
3	Бизнесээ хөгжүүлэх сургалт эхний өдөр	2024.10.31	09:30-17:00		Бизнесээ хөгжүүлэх, ашиг орлогоо нэмэгдүүлэх арга замууд: Бүрэн хамрагдсан бол сертификат олгоно.	Цайны завсарлага, өдрийн хоолтой
4	Бизнесээ хөгжүүлэх сургалт хоёр дахь өдөр	2024.11.01	09:30-17:00			Цайны завсарлага, өдрийн хоолтой
5	Удирдах ажилтнуудад зориулсан ХАБЭА-н сургалт	2024.11.02	09:30-17:00		Өөрийгөө болон багийн гишүүнээ ажуул, эрсдэлээс сэргийлэх тухай. Бүрэн хамрагдаж, шалгалтдаа тэнцсэн бол сертификат олгоно.	Цайны завсарлага, өдрийн хоолтой
6	Шинээр хамтран ажиллах болсон бичил, жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан зөвлөмж	2024.11.03	10:30-13:30		Хамтран ажиллах Санамж бичиг байгуулах, багажны багц гардуулах, зах зээлээ холбох	Цайны завсарлагатай

"Дулаалгын ажилтан" багц сургалтад бүрэн хамрагдсан барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчид "Дулаалгын зөвлөх" багц сургалтаар чадавхжих эрх үүсэх.

"Дулаалгын зөвлөх" багц сургалтад бүрэн хамрагдсан, цаашид барилгын эрчим хүчний хэмнэлт, дулаалгын чиглэлээр ажиллах сонирхолтой хувь хүн, бригад, аж ахуйн нэгж нь 2024.11.03-ны арга хэмжээнд хамрагдана.

Асууж тодруулах зүйл, санал байвал 8001-9000 дугаарын утсаар холбогдоорой.

** Сургалтад оролцогчид бичиж тэмдэглэх үзэг, дэвтэртэй, өөрийн үсчы сав/халууныа барьдаг аяатай ирэх*

МБҮА ТББ-ын Төслийн баг нь Дархан-Уул аймгийн барилгын салбарын бичил, жижиг бизнес эрхлэгчдэд зориулан хоёр үе шаттай чадавхжуулах багц хөтөлбөрийг зохион байгуулахаар төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу 2024.10.16-10.19-ний өдрүүдэд эхний шатны “Дулаалгын ажилтан” багц хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлсэн болохоо дээр мэдээлсэн. Тэгвэл дээрх зурагт харуулснаар, хоёр шатны “Дулаалгын зөвлөх” багц чадавхжуулах хөтөлбөрөө эхний шатанд хамрагдсан барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчдэд зориулан 2024.10.29-нөөс эхлэн зохион байгуулж байна. 2024.11.02-ны өдрийг дуустал явагдах багц хөтөлбөрийн хүрээнд одоогийн байдлаар “Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ, дулаалгын платформ”, “Дулаалгын зах зээл, маркетинг, борлуулалт”, “Бизнесээ хөгжүүлэх мэдлэг олгох” гэсэн 3 төрлийн сургалтаа зохион байгуулаад байгаа юм.

“Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ, дулаалгын платформ” сургалт:





- **Огноо:** 2024.10.29-10.30
- **Байршил:** Дарханы ХААИС
- **Хамрагдсан хүний тоо:** 28
- **Гол агуулга:** Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, хэмжих, вэб суурьтай үнэлгээний маягт болон дулаалгын гүйцэтгэлийн акт бөглөх тухай
- **Зохион байгуулагч:** ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв
- **Багш:** Ахлах инженер Ж.Ганхуяг
- **Хамтрагч:** МБҮА ТББ


“Дулаалгын зах зээл, маркетинг, борлуулалт” сургалт:





- **Огноо:** 2024.10.30
- **Байршил:** Дарханы ХААИС
- **Хамрагдсан хүний тоо:** 28
- **Гол агуулга:** Хувийн сууцны дулаалгын үнэлгээ, тооцоолол гаргах, ногоон зээл санал болгох тухай, төслийн хэмжилт, үнэлгээ, дулаалгын ажлуудын захиалга авахдаа маркетинг, борлуулалтаа хийх арга зам, зааварчилгаа
- **Зохион байгуулагч:** МБҮА ТББ
- **Багш:** Э.Лхагвасүрэн, М.Маргад
- **Хамтрагч:** Жэрэс ОУТББ

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭ ИЛЭРХИЙЛЭВ



Жэрэс ОУТББ-ын Азийн бүс хариуцсан захирал, тус байгууллагын Монгол дахь Суурин төлөөлөгчийн түр орлон гүйцэтгэгч Квинтин Морро болон МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх нар 2024.10.29-нд уулзаж санал бодлоо солилцлоо. Уулзалтаар талууд өмнөх сайн туршлагад үндэслэн цаашид МБҮА ТББ, түүний төслийн нэгжийг үр дүнтэй удирдаж, үйл ажиллагааг нь улам сайжруулан ажиллах болно гэдгээ илэрхийллээ. Улмаар МБҮА ТББ нь төслийг цаашид үргэлжлүүлэхэд чухал үүрэгтэй хамтран хэрэгжүүлэгч гэж үнэлсэнд баяртай байгаа ба төслийн хэрэгжилтийн үе болон төсөл дууссаны дараах тогтвортой байдлыг хангахад анхаарч ажиллах болно. МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл II” төслийн багийг 2024-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд удирдлагын зүгээс дэмжиж ажиллах ба төслийн үйл ажиллагааг тасралтгүй явуулж, гэрээний үүргээ биелүүлж ажиллах болно. Тиймээс энэхүү хамтын санхүүжилтийг төсөл дуусах үе хүртэл үе шаттайгаар олох бөгөөд энэ тал дээр УЗ-ийн гишүүд дэмжин хамтран ажиллахаа илэрхийлэв.

“ДУЛААН ШИЙДЭЛ-2 ТӨСӨЛ”-ИЙН БАГИЙН 10-Р САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ

Д/Д	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ТООН ҮЗҮҮЛЭЛТ
1.	ББЖБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	41
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан ББЖБЭ-ийн тоо	12
3.	ББЖБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	30
4.	ББЖБЭ-дэд зуучилсан дулаалгын ажлын тоо	6
5.	ББЖБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	8
6.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон ББЖБЭ-ийн тоо	244
7.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн ББЖБЭ-ийн тоо	40
8.	Техникийн үнэлгээ, дулаалга болон барилгын ажлын талаар гарсан санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн харилцагчдын тоо	6


АЖЛЫН АЛБАНЫ БҮАТЗХ-ИЙН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН ТОЙМ


БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 500 гаруй ААНБ, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав.





БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг хүссэн 146 ААНБ-ын хүсэлт, материалыг баталгаажуулж, ХББОСЯ-нд 2024.10.03, 2024.10.10, 2024.10.17, 2024.10.24, 2024.10.31-ний өдрүүдэд тус тус цахимаар илгээв.





Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 361 ААНБ-ын хүсэлт хянагдаж, 5 удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар 146 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав.

Үүнээс: Сунгалтаар 3, Нэмэлтээр 46, Шинээр 97 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Сунгалтаар 3 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 1, Зураг төсөл боловсруулалтаар 2, Нэмэлтээр 46 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 38, Зураг төсөл боловсруулалтаар 8, Шинээр 97 ААНБ-ын хүсэлтийг хянаснаас: Барилга угсралтаар 82, Зураг төсөл боловсруулалтаар 13, Өргөх байгууламжаар 2 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Эдгээр 5 удаагийн хурлаар давхардсан тоогоор 191 ААНБ-ын материалыг шаардлага хангаагүйн улмаас буцааж, 24 ААНБ-ын хүсэлтийг шалгахаар хүлээгдэж байна.

- Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 146 ААНБ-ын хүсэлтийн материалыг хянаж, 659 инженер, техникийн ажилтнуудын баталгаажуулалтыг хийв.
- Монгол Улсын Засгийн газрын “Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал”-д нийтлэх БҮАТЗ-ийг эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, 5 удаа ХББОСЯ-нд хүргүүлэв. Улсын бүртгэлийн ерөнхий газрын *opendata.burtgel.gov.mn*-д БУ: 4,247, ЗТ: 854, ӨБ: 159 ААНБ-ын нийт 5,260 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- БҮАТЗ-тэй ААНБ-уудын мэдээллийн санг үүсгэн *www.mcis.gov.mn*-ын “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 4,247, ЗТ: 854, ӨБ: 159 ААНБ-ын нийт 5,260 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам (ЦХХХЯ)-ны тусгай зөвшөөрлийн цахим системд БУ: 135, ЗТ: 21, ӨБ-5 ААНБ-ын мэдээллийг илгээв.
- ХББОС-ын Сайдын тушаалыг үндэслэн 136 ААНБ-тай гэрээг байгуулж, Засгийн газрын “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох” тогтоолын дагуу 134,00,000 төгрөгийн Улсын тэмдэгтийн хураамжийг Худалдаа, хөгжлийн банкны дансанд төвлөрүүлэв.
- Үйлчилгээний хөлсний 146 ААНБ-ын 86,600,000 төгрөгийг Худалдаа, хөгжлийн банкны 431006029 тоот дансаар төвлөрүүлэн ажиллав.

ХББОС-ын Сайдын 2024.10.02-ны өдрийн тушаал №61, 2024.10.14-ний өдрийн тушаал №69, 2024.10.22-ны өдрийн тушаал №76, №77 дугаар тушаалыг үндэслэн үнэт цаасанд бичилтийг хийж, баталгаажуулав.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

- ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Л.ЭНХ-АМГАЛАН-д “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-ийн 19.1.2 заалтыг хүчингүй болгох асуудлаар МБҮА ТББ-ын 2024.10.31-ний өдрийн 24/80/АА тоот албан бичиг
- МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ-Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн асуудлаар МБҮА ТББ-ын 2024.10.30-ний өдрийн 24/79/АА тоот албан бичиг
- ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН-д барилга барих, ашиглалтад өгөх, техникийн нөхцөл олгох, галын зөвшөөрөл авч эх загвар зураг/эскиз/, иж бүрэн ажлын зураг батлуулах зэрэг үйл ажиллагаанд гарч байгаа хүнд суртал, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх асуудлаар МБҮА ТББ-ын 2024.10.30-ний өдрийн 24/78/АА тоот албан бичиг
- ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГА Ч.ТӨГСДЭЛГЭР-д Нийслэлийн бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэх, Нийслэлийн газар, техникийн нөхцөл олгох, барилга барих, ашиглалтад авах, эскиз зураг батлуулах зэрэг зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд гарч байгаа хүнд суртал, хугацаа алдалт, саатал дутагдлыг засах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан хамтарсан уулзалтыг 11 дүгээр сард хийж , ярилцах талаар МБҮА ТББ-ын 2024.10.30-ний өдрийн 24/77/АА тоот албан бичгүүдийг тус тус хүргүүллээ.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.4



ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

- МБҮА ТББ-ын 2024 оны 1-3-р улирлын тайлангийн танилцуулга, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тодотголыг шинэчлэн боловсруулж Удирдах зөвлөлийн гишүүдэд и-мэйлээр илгээсэн.
- “Барилга, дэд бүтцийн олон улсын арбитр байгуулах төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”, “Фидикийн олон улсын жишиг гэрээний орчуулгын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г тус тус хянаж шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулж батлуулсан.
- МБҮА ТББ үүсэн байгуулагдсаны 15 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой Ажлын албаны зарим албан хаагчдыг төрийн одон медаль болон яамны шагналд нэр дэвшүүлж материалыг хүргүүлсэн.
- МБҮА ТББ-ын Ажлын албаны албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зорилгоор эмнэлгүүдийн судалгааг гарган мөн зардлын төсвийг бэлтгэн Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгчид танилцуулсан.
- Фидикийн сургалт авахыг хүссэн албан байгууллага руу Үнийн саналыг боловсруулан сургалтын хөтөлбөрийн хамт илгээсэн.
- Гишүүн компаниудын удирдлагуудын дунд “Манлайлал ба менежерийн үндсэн 7 ялгаа” сэдэвт сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

ДОТООД АЖЛЫН ХҮРЭЭНД:

МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчдийн зөвлөлийн 2024.10.17-ны өдрийн хурлаар хөтөлбөр бэлтгэж энэ хурлаар дараах асуудлыг хэлэлцэв Үүнд:

- МБҮА ТББ-ын 2024 оны үйл ажиллагааны тодотгосон төлөвлөгөө, төсвийн төсөл
- МБҮА ТББ-ын 15 жилийн ойн арга хэмжээний хөтөлбөр,төсвийн тухай
- Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах бэлтгэл ажлын талаар
- Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын асуудал
- Удирдах зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудлын хөтөлбөр
- “Дулаан шийдэл-2” төслийн санхүүжилт, хэрэгжүүлэх зарим арга хэмжээний санал

Удирдах зөвлөлийн 2024.10.25-ны өдрийн хурлаар хэлэлцсэн асуудлаар МБҮА ТББ-ын УЗХ-ын дараах тогтоолуудын төслийг Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, Хуулийн зөвлөх нарт танилцуулж эцэслэн тохирч, албажуулав. Үүнд:

- 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах тухай 2024.10.25-ны өдрийн 06 дугаар тогтоол
- Гүйцэтгэх захирлыг томилох тухай 2024.10.25-ны өдрийн 07 дугаар тогтоол
- Санхүүгийн аудит хийлгэх тухай /МБҮА ТББ-ын 2023,2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэх/2024.10.25-ны өдрийн 08 дугаар тогтоол
- 15 жилийн ой тэмдэглэх төлөвлөгөө, төсөв батлах тухай 2024.10.25-ны өдрийн 09 дүгээр тогтоол
- “Дулаан шийдэл-2” төслийн хамтарсан санхүүжилтийн тухай 2024.10.25-ны өдрийн 10 дугаар тогтоолуудыг албажуулан гаргав.



ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.6

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МБҮА ТББ-ын 2024.10-р сарын байгууллагын өдөр тутмын гүйлгээ, ашиглалт, түрээс, интернэт болон бусад холбогдох төлбөрийг цаг тухайд нь төлөв. “Дулаан шийдэл-2” 8,9,10-р сарын төслийн сарын гүйлгээ болон цалин хөлсийг бодож, тухайн саруудын тайланг бэлдэн гүйцэтгэв. Санхүүгийн программ дээр холбогдох журналын бичилт болон данс хоорондын төлбөр тооцоог тулгаж гүйлгээнүүдийг хийв. Төслийн сар бүрийн санхүүгийн товлогдсон хуралд сууж, зөвлөмж чиглэлийг мөрдөн ажиллав. БҮАТЗ-ийн хураамж төлөлтийн дагуу И-баримтыг холбогдох компани руу шивж ажиллав.10-р сарын НДШ тайлан, НӨАТ-н тайланг гаргав. 2024 оны 3-р улирлын ААНОАТ,ХАОАТ, Санхүүгийн тайлан болон Тусгай зөвшөөрлийн төсвийн тодотгол хийж тайлагнасан. Тухайн сарын өдөр тутмын ажлын үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэсэн.

(МБҮА ТББ-ЫН 2024.09.30-НЫ ӨДРИЙН БАЙДЛЫН САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ)

Утга	Ажлын алба (₮)	БҮАТЗ (₮)
Харилцахын эхний үлдэгдэл	167,399,229.53	695,175,246.20
10-р сарын орлого	121,515,914.65	131,205,167.54
10-р сарын зардал	19,452,516.56	80,539,932.58
Харилцахын эцсийн үлдэгдэл	269,462,627.62	745,840,481.16



2024



ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.8

ТӨР-ХУВИЙН ХЭВШЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



“Монголын орон сууцны ирээдүй 2024” олон улсын форумыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Дэлхийн банк, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран энэ сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх өнөөгийн бодит боломж, санхүүжилтын бодлого, орлогод нийцсэн орон сууц, олон улсын туршлагыг нэвтрүүлэх арга зам юу байгааг хөндөж талууд байр сууриа илэрхийллээ. Тус хуралд МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан дараах хариултыг өгсөн юм.

-Барилгын үнэ өндөр байгаа шалтгааныг тайлбарлаж өгнө үү.

Өнөөдрийн энэ хуралд бүх талуудын оролцоог хангаж, байр сууриа илэрхийлэх боломжоор хангаж байгаад юуны өмнө талархал илэрхийлье. Байр орон сууцны үнэ нэмэгдэж байгаа асуудал нь биднээс хамаарах хамаарахгүй олон хүчин зүйлээс болж байна. Үнэд хамгийн их нөлөөлж байгаа зүйл бол нэгдүгээрт газар, хоёрт ний нуугүй хэлэхэд авлигын үнэ байгаа. Хэвлэл мэдээллийнхэн их ирсэн байна. Хувийн хэвшлийн төлөөллүүд маань хэлж магадгүй байх гэж бодож байна. Өнөөдөр барилга эрхлэх зөвшөөрөл авах, А даалгавар авахад бүтэн 5 сар болж байгаа. Энэ тогтолцоогоос манай барилгын яам реформ хийж эхлэх болов уу гэж бодож байна. Үүнийг бүгд мэддэг. Томхон компаниуд үүнийг үл тоож зөвлөх үйлчилгээний зардалдаа оруулж явдаг. Дунд зэргийн компаниуд үүнийг нэлээн зовж байж авдаг. Гэхдээ үүнийгээ олон компани хэлдэггүй. Тухайлбал галын зөвшөөрөл авах гэж хоёр сар болж байна, жишээг цааш нь хэлж болно. Наадам боллоо, 100 жил боллоо, өнөө галын газар өгөхгүй. Нөгөө зөвшөөрөл өгөх болоход хоёр нь зэрэгцээд амраад алга болдог. Том асуудлуудаа цэгцлэхийн тулд суурь асуудлуудаа бэлдэх хэрэгтэй байна. Цаашаа явахын тулд хувийн хэвшлүүдээ түлхүү оруулж хамтарсан төсөл хэлбэрээр төсөлжүүлэх маягаар явах хэрэгтэй болов уу. Үүнийг дагаад авлига хээл хахууль манай барилгын салбарт байгаа.

-Гэр хорооллын дахин төлөвлөлтөд барилгын компаниуд ямар суурьтай оролцох сонирхолтой байгаа вэ?

-Зах зээл дээр компаниуд том жижиг дунд гээд олон төрлийн байгаа. Мэдээж энэ төслүүдэд бүх л компаниуд оролцохыг сонирхож байгаа. Юуны түрүүнд гэр хорооллолд байгаа иргэдэд бүсчилсэн ерөнхий төлөвлөлтийг тодорхой болгох хэрэгтэй байна. Мэргэжлийн судалгаа хийгээд хаана хаана, орлогод нийцсэн орон сууцаа барих хэрэгтэй байна. Тийм бишээс болоод газрын наймаа, ухаандаа 2 буудлын зайд газар аваад барилгын компанид зардаг, тэгэхээр үнэ өсөх нь тодорхой. Хэрэв бүсчиллээ тодорхой болгочих юм бол аль барилгын компани хаана орох нь тодорхой болно. Бас нэг юм нэмээд хэлэхэд гэр хорооллын газрууд гараад байхад, тэр газар дээр яагаад А даалгавар өгөөд байна аа. Үүнийг хуульчилж зогсоохгүй бол нөгөө төлөвлөлт хийгээд томоор хийх гэж байгаа газруудын үнэ цэнийг бууруулаад байна. Нөгөө үнэтэй авсан газраа компаниуд хүн амьдрах орчингүй, газраа дүүртэл нь төлөвлөж байна. Тиймээс үүнийг яаралтай хуульчлах хэрэгтэй. Мөн гэр хорооллолд эрчим хүчний хэмнэлттэй амины нам давхрын орон сууцууд хашаанд нь барих хөтөлбөр хэрэгжүүлэхэд нэг анхаарах зүйл бий. Улсаас дэд бүтцийн нь тавиад эхлэнгүүт тэр хэсгийн газрын үнэ шууд өсдөг. Энэ тохиолдолд айлууд бас л барилгын компаниудад газраа өндөр хүргэж зарах сонирхол бий болно. Энд бас дээрх гажуудал

давтагдана. Олон улсын туршлага, тухайлбал Холбооны Бүгд Найрамдах Герман улсад давхрын тоог заахаас гадна байшингийн өндрийн хэмжээг заадаг, тэдэн метр өндрөөс дээш хэтрүүлж болохгүй гээд. Зарим нэг хотод дээврийн налууг градусыг хүртэл заадаг. Энэ мэтчилэн стандартуудыг хатуу хуульчлахгүй бол айлууд газраа зараад нөгөө сайхан төлөвлөлтүүд нь үгүй болж бие биеэ хаасан өндөр барилгууд баригдана. Жишээлбэл Гандан, Зайсан, Нэхмэлийн шарууд,100 айл, Яармаг, Натур төвийн ойролцоох газруудад барилгажсан алдааг давтахгүй байя.

ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО ОЛОН УЛСЫН ФОРУМД БАРИЛГЫН САЛБАРЫНХАН БАЙР СУУРИА ИЛЭРХИЙЛЛЭЭ

“Монголын орон сууцны ирээдүй 2024” олон улсын форумыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Дэлхийн банк, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран зохион байгуулсан тус хэлэлцүүлэгт орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх өнөөгийн бодит боломж, санхүүжилтын бодлого, орлогод нийцсэн орон сууц, олон улсын туршлагыг нэвтрүүлэх арга зам юу байгааг хөндөж байлаа.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь: “Ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2025 онд 1.2 их наяд төгрөгт хүргэх бөгөөд жил бүр тус эх үүсвэрийг үе шаттайгаар нэмэгдүүлж, 2028 он гэхэд 60 мянган айл өрхийг ипотекийн зээлд хамруулна. Мөн ипотекийн зээлийн 50-иас дээш хувийг орон нутагт олгохоор төлөвлөж байна. Ирэх 4 жилд 150 мянган айлын орон сууцыг ашиглалтад оруулна. “Монголын Ногоон Санхүүгийн Корпораци”-тай хамтран олон улсын санхүүгийн эх үүсвэрээс хөрөнгө оруулалт босгож, амины орон сууцаа дулааны алдагдалгүй болгосон иргэдэд хөнгөлөлттэй зээлийг олгох, дэд бүтцээ бүрэн шийдвэрлэсэн өрхөд төрөөс 30 хүртэлх сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэдгийг тодотголоо.

Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө иргэдийг орон сууцжуулах тодорхой зорилтуудыг тусгасан бөгөөд

- Үндэсний баялагын сангаар дамжуулан орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх
- Ипотекийн зээлийг өрхийн орлогын түвшинтэй уялдуулах
- Үндэсний орон сууцны корпораци байгуулж, орон сууцжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, амины орон сууцыг нэмэгдүүлэхэд хөнгөлөлттэй зээл, урамшууллын механизмыг нэвтрүүлэх
- Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор “Шинэ зуунмод”, “Шинэ Хархорум” зэрэг хотуудыг шинээр байгуулах
- Аймаг, сум, орон нутагт орон сууцжуулалтын үйл ажиллагааг бодлогоор дэмжих зэрэг болно.

Улсын Их Хурлын намрын чуулганаар Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төсөл зэрэг Барилгын салбарын багц хуулийн төслүүдийг боловсруулан, өргөн барьж, батлуулахаар ажиллаж байгааг бодлого боловсруулагчид хэлж байна. Хэлэлцүүлэгт Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Дэлхийн банкны орон сууцжуулалтын ахлах мэргэжилтэн Дао Харрисон, Дэлхийн банкны санхүүгийн салбарын ахлах мэргэжилтэн Оливье Видал, Дэлхийн банкны хот төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Палави Сенгупта, Египетийн түрээсийн орон сууц, Ипотекийн санхүүжилтийн сангийн Ерөнхийлөгч Мэй Абдель Хамид Ахмед, Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын яамны Орон сууцжуулалтын хэлтсийн дарга Э.Батболд болон Монголын ногоон барилгын сангийн гүйцэтгэх захирал Ц.Батгэрэл нар илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүллээ.

МҮХАҮТ-ын ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ЕРӨНХИЙЛӨГЧӨӨ СОНГОХООР БОЛЛОО





МҮХАҮТ-ын Удирдах зөвлөлийн гишүүдийн ээлжит хурал 2024.10.16-ны өдөр болж 56 хүн оролцсоноос 42 гишүүн танхимаар, 14 гишүүн цахимаар оролцлоо. Тус хурлаар МҮХАҮТ-ын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны санхүүгийн тайлан, Хяналтын зөвлөлийн тайлан, МҮХАҮТ-ын УЗ-ийн Гишүүнийг нөхөн сонгох, танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрийн арбитрчдын жагсаалтад өөрчлөлт оруулах тухай, Аймгууд дахь ХАҮТ-ын санхүү ба бүртгэлийг хууль, журамд нийцүүлэх шаардлага, МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Д.Энхтүвшингийн хүсэлтийг хэлэлцэх талаарх асуудлуудаар зөвлөлдөж, санал бодлоо солилцлоо. МҮХАҮТ-ын Бодлого стратегийн газрын дарга Ж.Оюунчимэг танхимын бодлогын өмгөөллийн чиглэлээр хийсэн ажлуудыг, гүйцэтгэх захирал Т.Дүүрэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулсны дагуу гишүүдийн зүгээс тайлан тавих загварыг өөрчлөн гүйцэтгэл үнэлгээ буюу /KPI/-д суурилсан байдлаар танилцуулдаг болох, бизнесийн орчинд тулгарч байгаа асуудлуудыг эрэмбэлэн жагсааж, тэдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцаж шийдвэрлэдэг байх талаарх саналыг гаргалаа. Мөн МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрийн арбитрчдын жагсаалтад өөрчлөлт оруулах тухай танилцуулгыг хийсэн бөгөөд төр хувийн хэвшил хамтарсан гэрээ байгуулж үйл ажиллагаа явуулахад маргаан үүсвэл Арбитраар асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд төлбөрөө урьдчилаад төлдөг байдлыг хэргийн дараа нь төлдөг болгох талаар зохицуулалтыг Арбитрын хэрэг маргаан хянан шийдвэрлэх журамд оруулж өгвөл төртэй холбоотой үүссэн маргаанаас орлого олох боломжтой гэдгийг онцолсон юм. Хурлын төгсгөлд МҮХАҮТ-ын Ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт болоод улс төрийн нөхцөл байдлын талаар танилцуулж улмаар МҮХАҮТ-ын ээлжит бус Их хурлыг товлон Ерөнхийлөгчийн сонгуулийг яаралтай явуулах, Удирдах зөвлөлийн хурал, тэргүүлэгчдийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах талаар ярилцаж ээлжит бус хурлыг 2024.06.03-ны дотор МҮХАҮТ-ын гишүүнээр элссэн гишүүд оролцох эрхтэй байхаар тооцож 2024.11.18-22-ны хооронд хуралдуулахаар тогтлоо. Мөн энэ сарын 30-ны өдөр МҮХАҮТ-ын Тэргүүлэгч гишүүдийн хурал болж хурлаар МҮХАҮТ-ын үйлчилгээний үнэ тарифыг өөрчлөх тухай, Оны энтрепренёр шилдэг онцлох аж ахуйн нэгжийг шалгаруулах, зохион байгуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах, МҮХАҮТ-ын ээлжит бус их хурлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулах, ээлжит бус их хурлын төсвийг батлуулах, дэгийг хэлэлцэх, комиссын бүрэлдэхүүнийг батлуулах талаар хэлэлцлээ. Дашрамд дурдахад МБҮА ТББ нь МҮХАҮТ-ын Удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд бизнесийн орчин, тэр дундаа барилгын салбарын томоохон төлөөллүүдийг төлөөлдөг бөгөөд уг хуралд байр сууриа илэрхийлж оролцлоо.

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА ЖАЙКА-ТАЙ МБҮА ТББ-ЫН ГИШҮҮД САНАЛ СОЛИЛЦЛОО



Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА нь төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тулгамдаж байгаа асуудал болоод хувийн хэвшлийн оролцоог дэмжиж чадавхжуулах зорилгын хүрээнд салбар бүрийн ТББ болоод хувийн хэвшлийн төлөөллүүдтэй санал солилцох уулзалтын хүрээнд МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Б.Баасансүрэн, М.Батболд, Эн Эй Би ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Амарсанаа, МБҮА ТББ-ын Ажлын албаны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны менежер Б.Саранчимэг нар оролцож байр сууриа илэрхийллээ. ЖАЙКА- олон улсын байгууллагаас 2025 онд "Улсын хөрөнгө оруулалтыг зохистой удирдах замаар болзошгүй өр төлбөрийн эрсдэлийн менежментийн чадавх бэхжүүлэх төсөл"-ийн нарийвчилсан судалгааны багийн гишүүн ЖАЙКА-гийн Засаглал, энхтайвныг цогцлоох газрын Төрийн бодлого, санхүүгийн хэлтсийн дарга ноён Сэйичи НЭГИШИ, Төрийн бодлого, санхүүгийн хэлтсийн зөвлөх Сэйюү ХИЁОШИ, төслийн ажилтан Ш.Болор нар нь тус төсөлд хувийн хэвшил хэрхэн хамрагдаж, хамтран ажиллаж болох талаар танилцууллаа.



ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.6

ОЛОН УЛСЫН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ

АЗИЙН БА БАРУУН НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН ГЭРЭЭЛЭГЧДИЙН АССОЦИАЦИУДЫН ОЛОН УЛСЫН НИЙГЭМЛЭГ (IFAWPCA)-ИЙН **Int'l Federation of Asian and Western Pacific Contractors' Associations** 43 ДАХЬ УДААГИЙН ДУНД ХУГАЦААНЫ ЧУУЛГАН ТАЙВАНЬ УЛСЫН ТАЙБЭЙ ХОТНОО 2024.10.16-19-НЫ ӨДРҮҮДЭД ЗОХИОГДОЖ БАЙНА

Жил бүр уламжлан зохион байгуулагдаг АЗИЙН БА БАРУУН НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН ГЭРЭЭЛЭГЧДИЙН АССОЦИАЦИУДЫН ОЛОН УЛСЫН НИЙГЭМЛЭГ (IFAWPCA)-ийн дунд хугацааны чуулган 2024.10.16-ны өдрөөс эхлэн 3 хоногийн турш Тайвань Улсын Тайбэй хотноо эхэллээ.

Энэ удаагийн чуулган уулзалтаар (IFAWPCA)-ийн гишүүн орнуудын Ассоциациудыг олон талт хамтын ажиллагаагаа нягтаршуулах, туршлага судлах хүрээнд гишүүн орнууд нь хамтран ажиллах нөхцөл бололцоог нэмэгдүүлэх, улмаар дараагийн Дунд хугацааны болон Ерөнхий чуулганы тов, түүний бэлтгэл ажил, зохион байгуулалт, зэрэг асуудлуудыг хэлэлцэхээр байна.

МБҮА ТББ нь олон талт хамтын ажиллагааныхаа цар хүрээг улам тэлэн өргөжүүлснээр Азийн ба баруун номхон далайн гэрээлэгчдийн ассоциациудын Олон улсын Нийгэмлэг (IFAWPCA)-т 2015 онд анх гишүүнээр элсэж, улмаар 2018 онд Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож, (IFAWPCA)-ийн үйл ажиллагаанд жил бүр идэвхтэй оролцож хамтран ажилласаар ирсэн бөгөөд энэ удаагийн чуулганд амжилт хүсэн МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь ЦАХИМ МЭНДЧИЛГЭЭ-г илгээлээ.

МБҮА ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАЯРСАЙХАНЫ АЗИЙН БА БАРУУН НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН ГЭРЭЭЛЭГЧДИЙН АССОЦИАЦИУДЫН ОЛОН УЛСЫН НИЙГЭМЛЭГ (IFAWPCA)-ИЙН 43 ДАХЬ УДААГИЙН ДУНД ХУГАЦААНЫ ЧУУЛГАНД ИЛГЭЭСЭН МЭНДЧИЛГЭЭ


MNCA 15 Lead in the right towards.

43rd IFAWPCA Taipei, Taiwan

GREETING

TO THE 43RD MID-TERM EXECUTIVE BOARD MEETING OF THE INTERNATIONAL FEDERATION OF ASIAN AND WESTERN PACIFIC CONTRACTORS' ASSOCIATIONS (IFAWPCA)

Esteemed Mr.Kenneth Loo, President of the IFAWPCA,
Distinguished Presidents, Heads, and Members of the participating construction and other international associations,
Honourable guests,
Ladies and Gentleman,

First of all, I extend my warmest greetings to you, all the participants of the 43rd Mid-Term Executive Board Meeting of the IFAWPCA, personally and on behalf of the colleagues of the MNCA NGO and wish you every success in your important work.

The MNCA is proud of establishing a cooperation with the IFAWPCA in 2010, becoming a regular member in 2014 and a member of the Board of Directors in 2018 and happy to work with you up to date.

It is an honor for us to join the IFAWPCA family, which provides opportunities of broad development by making partners and exchanging experiences regularly.
By becoming an Associate Member of the FIDIC in 2022, with the support of IFAWPCA, MNCA has started introducing and implementing FIDIC standard contracts throughout Mongolia.

In the past, we have been actively participating in the activities of the IFAWPCA and successfully organized the 42nd Mid-term Executive Board Meeting of the IFAWPCA on the ERA OF INTERNATIONAL SUSTAINABLE BUILDING for the first time in June 2023, in Ulaanbaatar Capital of Mongolia in collaboration with the Ministry of Construction and Urban Development and IFAWPCA, and gave us a great chance to attract major foreign Contractors to Mongolia and current situation of our country to major foreign Contractors. It is my pleasure to recall these days spent together with you in Ulaanbaatar.

I apologize for not been able to attend the 43rd IFAWPCA Mid-term Executive Board Meeting in Taiwan in person due to internal issues. Because the Meeting coincides with recent the election of the Parliament, the highest governing body of Mongolia, a new government has been formed and ongoing local elections.

This year is very special because it is the starting year for the intensive implementation of major construction projects such as New Cities, Ulaanbaatar City Redevelopment, and Ulaanbaatar Metro.

It is a matter of great honor and privilege to say that the MNCA will continue strengthening and further developing cooperation with IFAWPCA.
I highly appreciate your cooperation and wish you a great success in this Board meeting.

Thank you for your attention.

BAYARSAIKHAN NYAMRAGCHAA, PRESIDENT OF THE MNCA NGO

IFAWPCA-ийн ерөнхийлөгч эрхэмсэг ноён Кеннет Лу,

Эрхэм хүндэт Ерөнхийлөгч, Тэргүүлэгч, хуралд оролцож буй барилгын болон бусад олон улсын нийгэмлэг, холбоодын гишүүд ээ.

Эрхэм зочид оо,

Хатагтай, ноёд оо,

Юуны өмнө, Ази, Баруун номхон далайн орнуудын гэрээлэгчдийн ассоциациудын олон улсын нийгэмлэг (IFAWPCA)-ийн Гүйцэтгэх Зөвлөлийн 43 дахь удаагийн дунд хугацааны хуралд оролцож буй нийт оролцогчид та бүхэнд хувиасаа болон МБҮА ТББ-ын нийт хамт олны нэрийн өмнөөс чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлж, үр өгөөжтэй хамтын ажиллагааг түүчээлэн өрнүүлж байгаад амжилт хүсье.

МБҮА ТББ нь Азийн ба Баруун Номхон Далайн Орнуудын Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-тэй 2010 онд харилцаа холбоо тогтоож, улмаар 2014 онд албан ёсны гишүүн, 2018 онд Удирдах зөвлөлийн гишүүн болж өнөөдрийг хүртэл хамтран ажиллаж байгаадаа баяртай байна.

Найзалж нөхөрлөх, туршлага мэдээллээ тогтмол солилцож хамтдаа хөгжих бололцоо олгодог IFAWPCA-ийн гэр бүлийн гишүүн байгаа нь бидний хувьд нэр төрийн хэрэг билээ. МБҮА ТББ 2022 оноос IFAWPCA-ийн дэмжлэгтэйгээр Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо

(ФИДИК)-ны “Түншлэгч гишүүн” болсноор Монгол Улсын хэмжээнд ФИДИК-ийн жишиг гэрээг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.
Өнгөрсөн хугацаанд Азийн ба Баруун Номхон Далайн Орнуудын Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсоноор IFAWPCA-ийн 42 дахь Дунд хугацааны чуулганыг “ОЛОН УЛСЫН ТОГТВОРТОЙ БАРИЛГЫН ЭРИН” сэдвийн хүрээнд БХБЯ, IFAWPCA-тай хамтран Монгол Улсад анх удаа Улаанбаатар хотноо 2023.06-р сард амжилттайгаар зохион байгуулсан нь бидэнд эх орныхоо барилга, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, өнөөгийн бодит нөхцөл байдлыг гадаадын томоохон Гэрээлэгчдэд сурталчлан таниулах таатай боломжийг олгосон билээ. Та бүхэнтэй хамтдаа Улаанбаатар хотод өнгөрүүлсэн эдгээр өдрүүдийг эргэн дурсахад таатай байна. Тайвань Улсад зохион байгуулж буй IFAWPCA-ын 43 дахь удаагийн дунд хугацааны чуулганд дотоод асуудлын улмаас биечлэн оролцох боломжгүй болсондоо хүлцэл өчиж байна. Учир нь энэ жил Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ-ын сонгууль явагдаж, шинэ Засгийн газар байгуулагдаж, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгууль явагдаж буй энэ цаг үетэй тус хурал нь давхцаж буй юм. Энэ жил Шинэ хотууд, Улаанбаатар хотын дахин төлөвлөлт, Улаанбаатар хотын метро зэрэг томоохон бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүд эрчимтэй хэрэгжих гарааны жил болж байгаагаараа онцлог юм. МБҮА ТББ нь IFAWPCA-тай хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж, улам хөгжүүлж өргөжүүлнэ гэдгээ илэрхийлэх нь эрхэм дээд хүндлэл билээ.
Хамтын ажиллагаанд талархал илэрхийлж та бүхний энэ удаагийн удирдах зөвлөлийн хурлын үйл ажиллагаанд өндөр амжилт хүсье.
Анхаарал хандуулсанд баярлалаа.

GREETING OF MR.BAYARSAIKHAN, THE PRESIDENT OF THE MNCA NGO, TO THE 43RD MID-TERM EXECUTIVE BOARD MEETING OF THE INTERNATIONAL FEDERATION OF ASIAN AND WESTERN PACIFIC CONTRACTORS’ ASSOCIATIONS (IFAWPCA)

Esteemed Mr.Kenneth Loo, President of the IFAWPCA,

Distinguished Presidents, Heads, and Members of the participating construction and other international associations,
Honourable guests,
Ladies and Gentleman,
First of all, I extend my warmest greetings to you, all the participants of the 43rd Mid-Term Executive Board Meeting of the IFAWPCA, personally and on behalf of the colleagues of the MNCA NGO and wish you every success in your important work.
The MNCA is proud of establishing a coooperation with the IFAWPCA in 2010, becoming a regular member in 2014 and a member of the Board of Directors in 2018 and happy to work with you up to date.
It is an honor for us to join the IFAWPCA family, which provides opportunities of broad development by making partners and exchanging experiences regularly. By becoming an Associate Member of the FIDIC in 2022, with the support of IFAWPCA, MNCA has started introducing and implementing FIDIC standard contracts throughout Mongolia.
In the past, we have been actively participating in the activities of the IFAWPCA and successfully organized the 42nd Mid-term Executive Board Meeting of the IFAWPCA on the ERA OF INTERNATIONAL SUSTAINABLE BUILDING for the first time in June 2023, in Ulaanbaatar Capital of Mongolia in collaboration with the Ministry of Construction and Urban Development and IFAWPCA, and gave us a great chance to attract major foreign Contractors to Mongolia and current situation of our country to major foreign Contractors. It is my pleasure to recall these days spent together with you in Ulaanbaatar.
I apologize for not been able to attend the 43rd IFAWPCA Mid-term Executive Board Meeting in Taiwan in person due to internal issues. Because the Meeting coincides with recent the election of the Parliament, the highest governing body of Mongolia, a new government has been formed and ongoing local elections.


This year is very special because it is the starting year for the intensive implementation of major construction projects such as New Cities, Ulaanbaatar City Redevelopment, and Ulaanbaatar Metro.
It is a matter of great honor and privilege to say that the MNCA will continue strengthening and further developing cooperation with IFAWPCA.
I highly appreciate your cooperation and wish you a great success in this Board meeting.
Thank you for your attention.

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ САНАЛ СОЛИЛЦЛОО




Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрөлжсөн агентлаг бөгөөд олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг тогтоож, хөдөлмөрийн хүрээний эрхүүдийг хангах, зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах, хөдөлмөрийн асуудлаарх нийгмийн түншлэлийг бэхжүүлэх чиглэлээр ажилладаг. МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл2” төслийн баг 2024.10.22-ны өдөр ОУХБ-ын ажилтнуудтай уулзалт хийж хоёр байгууллага хамтран ажиллах боломжуудын талаар ярилцлаа. ОУХБ нь МБҮА ТББ-тай барилгын салбарт албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийг устгах, жижиг бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, бизнесээ хэрхэн албажуулах асуудлаар сургалт, сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах боломжтой гэсэн мэдээлэл өгч, хамтран сургалт, чадавхжуулах ажил зохион байгуулах талаарх хүсэлтээ ОУХБ-д ирүүлэхийг зөвлөв. Мөн Дулаан шийдэл төслийн санхүүжилтийн асуудлын хувьд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн Сан хандах боломж байгаа талаар зөвлөлөө.

МАЛАЙЗЫН МАСТЕР БАРИЛГАЧДЫН ХОЛБОО (MBAM)-НООС БАРИЛГЫН САЛБАРТ УЧИРДАГ ТӨЛБӨР ТООЦОО, ШҮҮХИЙН ШИЙДВЭРЛЭЛТ ХЭРХЭН ЯВАГДДАГ ТАЛААРХ СУРГАЛТЫГ ХИЙЛЭЭ



Малайзын Мастер Барилгачдын Холбоо (MBAM)-ноос 2024.10.9, 22-ны өдөр зохион байгуулсан “Өөрчлөлт ба зөвлөмж”, “Барилгын салбарын төлбөр тооцоо ба шүүхийн шийдвэрийн тухай хууль” сэдэвт сургалтуудад оролцов. Сургалтуудаар барилгын гэрээнд өөрчлөлт оруулах шалтгаан нөхцөл, түүнд хэрхэн үнэлгээ хийх, шийдвэрлэх, барилгын салбарын төлбөрийн маргааны шалтгаан, барилгын салбарын төлбөрийг тогтмол, цаг тухайд нь олгох, маргааныг шүүхийн журмаар шуурхай шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх, төлбөрийг барагдуулах арга замыг бий болгосон хууль болох Малайзын “Барилгын салбарын төлбөр тооцоо ба шүүхийн шийдвэрийн тухай хууль”-ийн талаарх мэдээллийг өглөө.

ФИДИК-ИЙН МАЛАЙЗЫН МАСТЕР БАРИЛГАЧДЫН ХОЛБОО (МВАМ)-НООС БАРИЛГЫН САЛБАРЫН ИНЖЕНЕРҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ТАЛ ДЭЭР ТӨВЛӨРЧ АЖИЛЛАХААР БОЛОВ



Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (ФИДИК) нь 2024.10.29-ний өдөр зохион байгуулсан “Дэд бүтцийн салбарын маргаашийн ажиллах хүчнийг төлөвшүүлэх нь: Чадавх бэхжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх нь” сэдэвт вебинарт оролцлоо. Энэхүү хэлэлцүүлгийг ФИДИК-ийн дэд ерөнхийлөгч Жеймс Мванги удирдаж, хар арьст эмэгтэйчүүдийн эзэмшдэг инженерийн болон дэд бүтцийн хөгжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, Өмнөд Африкт хэмжээ, хүчин чадал, чадавхаараа хамгийн томд тооцогддог MPAMOT LLC-ийн захирал хатагтай Малани Падаячи-Саман, Египетийн Ta'heal for MET Skills Excellence-ийн гүйцэтгэх захирал хатагтай Шороке Зедан, Бразилын TPF Engenharia компаний хөгжлийн менежер ноён Артур Хенрике де Морайс Брито, Канадын AECOM компаний ахлах архитектор хатагтай Майя Чоудхури, Их Британийн Arcadis компаний Цаг уурын инженер хатагтай Мичеала Чан нар панелистаар оролцлоо. Энэ хэлэлцүүлгээр ФИДИК-ээс бэлтгэн гаргасан “Дэд бүтцийн салбарын маргаашийн ажиллах хүчнийг төлөвшүүлэх нь: Чадавх бэхжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх нь” тайлангийн талаар ФИДИК-ийн Бодлого, тогтвортой байдлын асуудал хариуцсан газрын дарга Басма Эйсса танилцуулж, панелистууд залуу ажилтнууд ялангуяа инженерүүдийг чадавхжуулах, ур чадварыг нэмэгдүүлэх асуудал улс орон бүрийн сорилт болж байгаа бөгөөд үүнийг даван туулах арга зам нь хамтын ажиллагаа түүний дотор төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, тогтмол сургалт зохион байгуулах, мэргэжлийн боловсролын сургуулиудыг чадавхжуулах, зөвлөгч (mentor) ажиллуулах зэрэг олон арга байж болох юм, гэхдээ хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудын хувьд мөнгө санхүүгийн дутагдалтай байдал гол асуудал болж байгааг ярилцлаа. Хэлэлцүүлгийн төгсгөлд ФИДИК-ээс гаргасан тайланг татаж авч үйл ажиллагаандаа хэрэглэхийг зөвлөлөө.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ
Монгол Улс, Улаанбаатар 15141
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

+(976) 70111515, 94444173

info@mnca.mn

www.mnca.mn